



**ХЭНГИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 09 сарын 20 өдөр

Дугаар Б/41.

Чингис хот

Э.Ариунтунгалагт жирэмсний болон
амаржсаны амралт олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 104 дүгээр зүйлийн 104.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч Э.Ариунтунгалагийн хүсэлтийг үндэслэн 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс жирэмсний болон амаржсаны амралт олгосугай.

2. Нягтлан бодогч Э.Ариунтунгалагийн ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Б.Цэцэгмаа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн Бүртгэлийн мэргэжилтэн
Гишүүд:	Ж.Саруултөгс	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн удирдлага, агентлаг хариуцсан мэргэжилтэн
	Т.Бямбадулам	Архив бичиг хэргийн эрхлэгч
	Т.Баяртуяа	Нярав

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн Бүртгэлийн мэргэжилтэн /Б.Цэцэгмаа/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР